



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 169

Улаанбаатар хот

Г Мэргэжлийн байгууллагуудын талаар Ү
авах арга хэмжээний тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан компаниудыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнээр элсэж, суудлын эрх авах хүртэл мэргэжлийн зуучлагчийн аливаа үйл ажиллагаа эрхлэхийг түр хугацаагаар хориглосугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Үнэт цаасны газар /Үнэт цаасны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Дүгэржав/, олон нийтэд сурталчлахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН